



43

БАЯНХОНГОР АЙМГИЙН  
БАЯНХОНГОР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/24

Номгон

Объектын гал түймрээс урьдчилан  
сэргийлэх талаар авах зарим арга хэмжээний  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Шадар сайдын 2023 оны “Гэр хорооллын айл өрхүүдийн галын аюулгүй байдал, урьдчилан сэргийлэх арга хэмжээний удирдамж”, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны “Ахуйн гал түймрээс урьдчилан сэргийлэх” аяны удирдамжийг хэрэгжүүлэх зорилгоор Баянхонгор сумын гэр хорооллын айл өрхүүдэд галын аюулгүй байдлыг хангуулах нэгдсэн хяналт шалгалтын ажлыг 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрөөс 02 дугаар сарын 19-ний өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулсугай.

2. Гэр хорооллын айл өрхүүдэд галын аюулгүй байдлыг хангуулах хяналт шалгалтын удирдамжийг нэгдүгээр, шаардагдах зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай;

3. Хяналт шалгалтын явцад цахилгаан дамжуулагч гэмтсэн, ашиглалтын явцад тусгаарлах чанараа алдсан шугам, дамжуулагч утсыг солих, засварлах, цахилгааны холболт зөрчигдсөн айл өрхүүдэд норм стандартын дагуу холбох талаар зөвлөгөө, зөвлөмж өгч ажиллахыг “Баянхонгор-Эрчим хүч” ЦТ ХХК-ийн захирал (Ж.Уламбаяр)-д;

4. Бага насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр гэрт нь үлдээхгүй байх, болзошгүй гал түймрийн аюулд өртөх, ахуйн осол, бэртэл, гэмтлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахыг багийн Нийгмийн ажилтнуудад;

5. Зохион байгуулж буй ажлын явц, үр дүнг иргэд, олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол мэдээлэх, сурталчлан ажиллахыг Хэвлэл мэдээлэл, олон нийт хариуцсан ажилтан (Д.Одонтунгалаг)-д;

6. Нэгдсэн арга хэмжээнд шаардагдах зардлыг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Хүрэлсүх)-д зөвшөөрсүгэй;

7. Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж, ажлын тайланг 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор сумын Онцгой комисст танилцуулахыг Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах 16 дугаар ангийн захирагч (ахмад Х.Цэнд-Очир)-д тус тус үүрэг болгосугай.


8. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил, арга зүйгээр ханган ажиллахыг Гал түймрийн улсын хяналтын байцаагч, (ахлах дэслэгч М.Төмөрчөдөр), Засаг даргын Орлогч (С.Батцэрэн) нарт тус тус даалгасугай;

ДАРГА



Г.ЭНХБАЯР

Баянхонгор сумын Засаг даргын 2023 оны  
02 дугаар сарын 07 -ны өдрийн А/24  
дүгээр захирамж 1 дүгээр хавсралт



45

ГЭР ХОРООЛЛЫН АЙЛ ӨРХҮҮДИЙН ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,  
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ

**Нэг. Зорилго**

Монгол Улсын хэмжээнд гарч буй гал түймрийн тоо хохирлыг бууруулах, гэр хорооллын айл өрхүүдэд гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх талаар үзлэг шалгалт зохион байгуулж, пийшин, зуух, яндангийн аюулгүй байдлын стандарт, норм, нормативыг мөрдүүлэх, галын аюулгүй ажиллагааны зааварчилгааг таниулах, олон нийтэд өргөн хүрээтэй сурталчлахад чиглэгдэнэ.

**Хоёр. Зохион байгуулах хугацаа**

2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрөөс 02 дугаар сарын 19-ний өдрүүдэд Баянхонгор сумын хэмжээнд зохион байгуулна.

**Гурав. Хамтран хэрэгжүүлэгч байгууллага**

Онцгой байдлын газар, Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн газар, Баянхонгор-Эрчим хүч цахилгаан түгээх ХХК хамтран зохион байгуулна.

**Дөрөв. Авч хэрэгжүүлэх арга хэмжээ**

- 1.Баянхонгор сумын гал түймэр гарах өндөр эрсдэлтэй айл өрхийн галын аюулгүй байдлыг хангах, болзошгүй гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх;
- 2.Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх санамжийг иргэд, олон нийтэд тараах, болзошгүй гамшиг осол, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр видео шторк хүргэх;

**Тав. Үр дүн**

Баянхонгор сумын айл өрхийн галын аюулгүй байдлыг хангаж, иргэд олон нийтэд болзошгүй гамшиг ослоос урьдчилан сэргийлэх материалыг тарааж, зохион байгуулалтын өндөр түвшинд хийж гүйцэтгэн нэгдсэн тайлан, мэдээг 2023 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор илтгэх хуудсаар холбогдох дээд шатны байгууллагад танилцуулна.

-----oOo-----



Баянхонгор сумын Засаг даргын 2023 оны  
 02 дугаар сарын 24 ны өдрийн 184 дүгээр  
 захирамжийн 2 дугаар хавсралт

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛД ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН ТООЦОО

1. Шатахуун

№	Авто машин	Улсын дугаар	Зарцуулах Шатахууны норм	Өдөрт туулах зам /км/	100 км-д зарцуулах Шатахууны норм	Өдөрт зарцуулах шатахуун	Хугацаа	Нийт зарцуулах шатахуун	Нийт дүн			
1	2	3	4	5	7	8	4	9	10			
1	Фургон	44-21 БНХ	18л	100 км	18 л	18 л	10 хоног	180 л	2530			
<b>Нийт</b>									<b>18л</b>	<b>180 л</b>	<b>10 хоног</b>	<b>455,400 төгрөг</b>

2. Сурталчилгааны материал

№	Нэр	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Тоо /ширхэг/	Нийтүнэ /төгрөг/
1	2	3	4	5
1	Тараах материал, Хэвлэмэл хуудас /Анонас/	350.000	1	350.000
<b>3</b>	<b>Нийт</b>			

3. Зардлын тооцооны нэгтгэл

№	Нэгдсэн тооцоо	Мөнгөн дүн /төгрөг/	Танилцсан
1	2	3	4
1	Шатахуун	455.400	
3	Хэвлэмэл хуудас	350.000	
<b>4</b>	<b>Нийт</b>	<b>805,400</b>	

\_\_\_\_\_ оОо